

1990-ээд оноос өмнөх барууны ба социалист киноны үзэл суртлын ялгаа, шашин шүтлэгийн илэрхийлэл

Дашзэвэгийн Ундраа, докторант

Монгол Улсын Их Сургууль, Философи, шашин судлалын тэнхим

Улаанбаатар, Монгол Улс, undrari@gmail.com,

<https://orcid.org/0009-0006-8482-4622>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

Үзэл суртал, Социалист реализм, Капитализм, Хамтын ажиллагаа, Хувь хүний үзэл, Суртал ухуулга, Хүйтэн дайн, Марксизм-Ленинизм, Шашин шүтлэг ба шашингүй үзэл, Монголын кино урлаг

Хураангуй: 1990-ээд оны эхээр, дэлхийн улс үндэстнүүд үзэл суртлын хоёр талбарт хуваагдаж, кино урлагт Барууны болон Социалист кино гэсэн хоёр өөр улс төр, соёлын үзэл баримтлалтай систем хөгжиж ирсэн түүх төгсгөл болов. Барууны кино нь капитализм, либерал ардчилалд суурилж, хувь хүний эрх чөлөө, ёс зүйн сонголт, уран сайхны илэрхийллийг голлож байв. Харин Социалист кино нь Марксизм-Ленинизмын үзэл санааг баримталж, улс төрийн боловсрол, хамтын ухамсар, нийтийн хөдөлмөр, эв нэгдэл, социалист үзлийг магтан дуулахад гол анхаарлаа хандуулж байлаа. Кино урлаг дахь энэхүү хоёр урсгалын сэдэв, зохиолын бүтэц огт өөр байв. Барууны кино хувь хүний хүчин зүтгэлийг илэрхийлэхэд төвлөрдөг байсан бол Социалист кино нь ажилчид, тариаланчид, дайчдын нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, шинэ ба хуучин нийгмийн хоорондох зөрчил тэмцэлд манлайлах үлгэр жишээ болж буйг магтан харуулдаг байв. Уран сайхны хандлага нь ч ялгаатай байсан юм. Барууны кино зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөл зүйл, шинэлэг байдлыг дэмжиж ирсэн бол Социалист кино нь социалист реализмын үзэл санааг хатуу барьж, ёс зүйн эерэг хандлага, үзэл суртлын чиг шугамыг илэрхийлж байв. Дайныг дүрслэхдээ, барууны кинонууд хувь хүний сэтгэл зүй, ёс зүйн эргэлзээг харуулдаг бол социалист кино эх оронч үзэл санаа, нийгмийн төлөө өөрийгөө золиослох хандлагыг магтан үзүүлж байлаа. Улс төрийн хувьд Барууны кино ёс зүйн хязгаарлалтыг дагаж, хувь хүний бие даасан байдлыг чухалчилж байсан бол, социалист кинонууд төрийн шууд хяналтанд байж, түүний суртал ухуулгын хэрэгсэл болж иржээ. Шашиныг илэхийлэхдээ ч ялгаатай байр суурьтай байсан юм. Барууны кино шашныг ёс зүй, амьдралын гүн ухаан гэдэг талаас үзүүлдэг байсан бол социалист кино шашныг мухар сүсэг гэж үзэн, социализмын хөгжил дэвшилд итгэх рационал хандлагыг уриалж байлаа. Ийнхүү 1990-ээд он хүртэл Барууны болон Социалист кинонууд нэг талаас, хувь хүн, либерал ардчиллыг сурталчилсан, нөгөө талаас хамтын нийгэм, социалист үзэл

суртлыг сурталчилсан гэсэн хуваагдлыг кино урлагт тусгасан тухай энэхүү өгүүлэлд ярих болно.

The Ideological Differences and Religious Representation in Western and Socialist Cinema before the 1990s

Undraa Dashzeveg, *doctor candidat*

Philosophy and Religion Studies, *National University of Mongolia*

Ulaanbaatar, Mongolia, undrari@gmail.com,

<https://orcid.org/0009-0006-8482-4622>

Keywords

Ideology, Socialist Realism, Capitalism, Collectivism, Individualism, Propaganda, Cold War, Marxism-Leninism, Religion and Atheism, Mongolian Cinema

© The Author(s), 2025



Abstract: Before 1990, during the final decades of the Cold War, Western and Socialist cinemas evolved within two ideologically opposed systems that reflected broader political and cultural divisions. Western cinema, rooted in capitalism and liberal democracy, emphasized individual freedom, moral choice, and artistic self-expression. Filmmakers such as Sidney Lumet explored ethical dilemmas and corruption through personal experience. In contrast, Socialist cinema, based on Marxist-Leninist principles, served as a medium of political education and collective consciousness, glorifying labor, unity, and socialist ideals. The thematic and narrative structures of the two traditions diverged sharply: Western films centered on individual struggle and the “American Dream,” while Socialist films idealized collective heroes — workers, peasants, and soldiers — engaged in the struggle between old and new social orders. Aesthetic approaches also differed; Western cinema fostered innovation and genre diversity driven by market demand, whereas Socialist cinema adhered to *Socialist Realism*, emphasizing didactic optimism and ideological clarity. Depictions of war further revealed ideological contrasts: Western films explored personal trauma and moral crisis, whereas Socialist works celebrated patriotic unity and sacrifice, exemplified by the Mongolian-Soviet production *Listen to the Enemy Soldiers!* (1971). Politically, Western cinema maintained relative independence despite moral restrictions such as the Hays Code, while Socialist cinema operated under direct state supervision as an explicit tool of propaganda. Religion was another defining point of divergence. Western cinema engaged with faith as a moral and existential question, whereas Socialist cinema rejected religion as superstition, replacing it with belief in reason, progress, and socialism. Ultimately, before 1990, Western and Socialist film industries functioned as opposing cultural instruments — one promoting individualism and liberal democracy, the other advancing collectivism and socialist ideology — together forming a cinematic reflection of the global ideological divide of the twentieth century.

1990 оноос өмнө (Хүйтэн дайны төгсгөл үед) Барууны болон Социалист кино урлаг нь үндсэндээ ялгаатай үзэл суртлын хүрээнд хөгжиж ирсэн юм. Тэдгээрийн гол үзэл суртлын ялгааг харьцуулан үзэхэд дараах дүр зураг харагддаг. Үүнд:

I. ҮЗЭЛ СУРТЛЫН ҮНДСЭН ЯЛГАА

1990 оноос өмнө, өөрөөр хэлбэл Хүйтэн дайны төгсгөл хүртэл Баруун ба Социалист кино нь нийгмийн улс төр, соёлын хуваагдлыг тусгасан, үндсээрээ өөр үзэл суртлаар бүтээгдэж байсан. Барууны кино нь капитализм, либерал ардчиллын үнэт зүйлд тулгуурлаж, хувь хүний эрх чөлөө, сонголт, хэрэглээ, өөрийгөө илэрхийлэх боломжийг дээдэлж байв. Харин социалист кино нь Марксист-Ленинист үзэл суртлын үндсэн дээр, хамтын ашиг сонирхол, нийгмийн тэгш байдал, ангийн ухамсрыг сурталчилж, кино урлагийг улс төрийн боловсрол, социалист нийгмийг байгуулах зэвсэг болгож байсан. (Peter Kenez. 1992)

Баруунд кино нь зах зээлийн эрэлт, ашиг орлогын төлөө чиглэсэн капиталист эдийн засгийн бүтээгдэхүүн байлаа. Голливуд болон Баруун Европын кино студи нь ашиг орлого, уран бүтээлчийн эрх чөлөө, үзэгчдийн сэтгэлийг татах чадварыг эрхэмлэж ажиллаж байв. Энэ нь найруулагчдад (хязгаартай ч гэсэн) төрийг шүүмжлэх, ёс суртахууны зөрчил мөргөлдөөнийг судлах, хувь хүний үзэл санаагаа илэрхийлэх боломж олгодог байв. Жишээлбэл, АНУ-ын найруулагчид болох Сидни Люмет, Фрэнсис Форд Коппола нар *Twelve Angry Men* (1957), *The Godfather* (1972) зэрэг кинонуудаараа шударга ёс ба авлигын асуудлыг хөндөж байв. (Tony Shaw, 2010)

Харин Социалист кино нь төвлөрсөн эдийн засагт төр ба коммунист намын үзэл суртлын салшгүй хараанд байв. Төрийн санхүүжилттэй, үзэл суртлын хяналттай кино студийн бүтээлүүд нь урлаг эсвэл хүмүүст зугаа цэнгэл өгөхөөс илүү, иргэдэд үнэнч гударга, хөдөлмөрч, хамт олонч, социалист үзэл ухамсар төлөвшүүлэхэд чиглэдэг байлаа.

Зөвлөлтийн кино найруулагч Сергей Эйнштейны “Броненосец Потемкина” (1925), Михаил Чиаурелийн “Падение Берлина” (1949) зэрэг бүтээлүүд нь хувьсгалт эв хамтыг алдаршуулж, социалист төрийг ажилчин анги, нийтийн эрх ашиг, хүсэл сонирхлыг илэрхийлэн хамгаалагч гэдэг талаас нь дүрсэлсэн байдаг. (Geoffrey Newell-Smith, 1996)

Социалист Монголын үед бүтээгдсэн “Морьтой ч болоосой” (1959) киноны найруулагч Р.Доржпалам, зохиолч Д.Гармаа. Уг киноны гол санаа “Уралдах уу? Уралдъя” гэсэн хэллэгээр илэрч байна. Урьд өмнө үзэж хараагүй явсан дөрвөн дугуйт машинаас илүүтэй аргамаг хурдан хүлэгтэй итгэх адуучин Дондогийн дүрээр инээдтэй боловч орчин цагийн техник технологийн хөгжлийн эхлэл хөдөөгийн ард түмэнд хэрхэн хүрч, ойлгогдож байсныг харуулдаг. Онцлог тал нь, социалист нийгмийн бүтээн байгуулалт, шинэ хүнийг төлөвшүүлэх үзлийг харуулсан инээдмийн өнгө аястай кино. Агуулга: Хувийн ашиг сонирхлоос илүү нийгмийн эрх ашгийг дээдэлдэг, социалист ёс суртахууныг сурталчилсан кино юм

“Хүний мөр” (1963) киноны найруулагч Д.Жигжид, зохиолч Л.Ванган. Ардын засгийн жилүүдэд Монголын сэхээтнүүдийн шинэ нийгэм, шинэ амьдралыг гардан байгуулах их үйлсэд оруулсан хувь нэмрийг өгүүлэхийн зэрэгцээ Монголын нийгмийн нэгэн хар толбо болж байсан хэлмэгдлийн үеийн дүр зургийг Чимид багшийн амьдралд тохиолдсон саад бэрхшээл, түүнийг хэрхэн даван туулж байгаагаар дамжуулан үзүүлжээ. Гол агуулга нь: Хөдөө орон нутгийн хөдөлмөрчдийн амьдралаар дамжуулан мөн л социалист ёс суртахууныг суртлачилсан. Киноны үзэл суртал нь: Төвлөрсөн эдийн засгийн үед хувь хүний хүсэл сонирхол нам,

төрийн зорилготой нийцэх ёстойг илэрхийлдэг.

Эдгээр кинонууд нь социалист реализмын хэв маягаар хийгдсэн бөгөөд төр засаг, намын үзэл суртлыг уран сайхны хэлбэрээр илэрхийлсэн, төвлөрсөн эдийн засгийн үед үзэл суртлын хяналт хүчтэй байсныг тод харуулдаг. (Монголын кино урлаг. 1989)

Сэдэв ба өгүүлэмжийн ялгаа

Барууны ба социалист киноны үзэл суртлын ялгаа нь киноны сэдэв, өгүүлэмжинд тод илэрдэг. (Платонова, Э.Е. 2003)

Барууны кино ихэвчлэн хувь хүний бэрхшээл, ялалтад төвлөрдөг ба “Америк маягийн мөрөөдөл”-ийн бэлгэдэл болсон бие даасан баатарлаг дүрүүдийг харуулдаг. Casablanca (1942) кинонд Рик Блейн эрх чөлөөний төлөө хувийн амьдралаа золиосолж байхад Easy Rider (1969) киноны мотоциклчид амьдралын утга учир, хувь хүний бие даасан байдлыг эрэлхийлж буй нь харагдана.

Харин социалист кино нь нийтийн баатарлаг дүрийг илүүд үзэж, ажилчин, тариачин, малчин анги болон цэрэг аоми нь бүх нийтийн зорилгын төлөө хамтран тэмцэж буйг илэрхийлсэн байдаг. Киноны гол зөрчил нь хувь хүний дотоод сэтгэлзүйд бус, харин нийгмийн доторх ангийн тэмцэл, хуучин ба шинэ ёс журмын хоорондох тэмцэл, хөрөнгөтний хувиа бодсон үзэл ба социалист хамтач үзлийн хоорондын тэмцлийг илэрхийлж байв. Социалист, коммунист нийгэм байгуулах ирээдүй рүү замнан дэвшиж буй түүхэн зайлшгүй хөгжил хөдөлгөөнийг мөн дүрсэлдэг байв. Зөвлөлтийн “Летят журавли” (1957) кинонд улс үндсээ сэргээн босгох нийтийн зорилгын төлөө хувь хүн өөрийгөө золиослож буй үйл явдал гардаг.

Монгол кино үйлдвэрийн бүтээл “Ардын элч” (1959) киноны найруулагч Д.Жигжид, зохиолч Ч.Ойдов. Хүн чанар, эх оронч сэтгэлгээг сэтгэл хөдөлгөм үйл явдлаар харуулсан тус кинонд үүрэг хариуцлагадаа эцсээ

хүртгэл үнэнч байсаар дайсны талын гарт үрэгдсэн эр нөхрийнхөө эцсийн захиасыг биелүүлэхээр Сүхбаатар жанжныг зорих эх, хүү хоёрын түүхийг харуулна. 1921 оны Ардын хувьсгалын үйл хэрэгт жирийн малчин ард хэрхэн оролцож байсныг, их жанжин Сүхбаатарт хүргэх нууц бичгийг авч явсан Дарьбазар дайсны гарт өртөн, амь үрэгдэхийн өмнө өөрийн зорьсон үйл хэргийг үргэлжлүүлэхийг гэргийдээ даатган дамжуулснаар Ариунаа зориг зүтгэл, авхаалж самбаа гарган, дайсны элдэв мөрдлөгөөс амь гарч, их жанжин Сүхбаатартай нүүр тулан учирч буй тухай өгүүлжээ. Энэ бол мөн л эх орон, ард түмэн, нийтийн тусын тулд амь биеэ үл хайрлах жирийн ардыг алдаршуулсан кино юм. (Монголын киноны шүүмж: 2015)

Урлагийн төрөл жанрын ялгаа

Барууны кино нь зах зээлийн зарчимд нийцүүлж, төрөл жанрын олон янз байдал, туршилт, инновацийг бүх талаар дэмждэг байв. 1960-аад оноос хойш найруулагчид хоёрдмол талтай (аль нэг талыг хэт баримтлахаас зайлсхийсэн) өгүүлэмж, гүнзгий сэтгэл хөдлөл, модернист арга барилыг судалж эхэлжээ. (Tony Shaw, 2010)

Харин социалист кино нь “социалист реализм” гэх албан ёсны гоо зүйн зарчмыг дагаж, бодит байдлыг өөдрөгөөр дүрслэх, социалист үнэт зүйлсийг алдаршуулахыг шаарддаг байв. Тодорхой ёс суртахууны чиглэлтэй, эцэст нь ялалт, цагаатгал, социалист үзэл санаан баталгаажуулж байгаагаар төгсдөг өгүүлэмжийг голчилно. Зөвлөлтийн “Баллада солдата” (1959) кино нь эгэл жирийн хүнийг ёс суртахууны үлгэр жишээ болгон харуулж, реализмийг уянгын сэтгэл хөдлөлтэй хослуулан дүрсэлжээ. Эйзенштейн, Пудовкин зэрэг Зөвлөлтийн найруулагчдын эхлүүлсэн кино зураглалын онол ч социалист киноны гоо зүйн үндэс болж, кино эвлүүлгийг зүгээр нэг зугаатай, сонирхолтой байх талаас бус, харин

үзэгчдийн оюун санаанд гүн нөлөөлөх суртал ухуулгын хэрэгсэл болгож ашигласан юм.

Дондогийн Цэвэгмэдийн зохиолоор Монгол кино үйлдвэрт бүтээсэн “Хоньчин Найдан” (1979) кино 1921 оны ардын хувьсгалын өмнөх монголчуудын хүнд бэрх амьдралыг бяцхан хүү Найдангийн дүрээр дамжуулан бодтой харуулах, Монголын ард түмэн ямар их зовлон амсаж, социалист нийгмийн сайн цагийн эхлэлтэй золгосныг уран сайхны реалист аргаар дүрслэхийг зорьсон кино юм.

Дайн ба хувьсгалыг дүрслэх нь

Барууны дайны кинонууд ихэвчлэн хувь хүний гэмшил, сэтгэлзүйн дотоод шарх, ёс суртахууны хямралыг харуулдаг (Жишээ нь: *The Deer Hunter*, 1978). Харин социалист кинонуудад дайныг эх оронч үзэл, эв хамтын нийгмийн төлөөх баатарлаг тэмцэл гэж харуулж, эв нэгдэл, эх орны төлөө хувь хүн өөрийгөө золиослох нь тэмцлийг ариун дээд илэрхийлэл хэмээн алдаршуулдаг байв. “Падение Берлина” тэргүүтэй Зөвлөлтийн кинонууд дайныг социализмын ялалт, Зөвлөлтийн ард түмний ёс суртахууны давуу талын илрэл гэж үзүүлсэн байдаг.

1971 онд Зөвлөлтийн найруулагч Борис Ермолаев, Монголын найруулагч Бадрахын Сумхүү нарын Монгол ба ЗХУ-д монгол, орос хэлээр бүтээсэн “Дайсны цэргүүдээ сонсоцгоо!” (Слушайте на той стороне) киноны агуулга нь: Халх голын дайнд онцгой даалгавар биелүүлж яваа Орос, Монголын хамтарсан тусгай отрядын байлдагчид нь дайны тэргүүн шугамд явж, үг хэл, дуу авиагаар сэтгэл санаа, үзэл суртлын хурц тэмцэл хийх хариуцлагатай үүргээ хэрхэн баатарлагаар биелүүлж буй үйл явдал гарна. Киноны баатруудын үйл ажиллагаа, бодол санаагаар дамжуулан Халх голын дайн, түүний далайц, Орос, Монгол дайчдын эх оронч үзэл, эв нэгдэл, хамтын хөдөлмөр зүтгэл,

социалист ёс суртахууныг алдаршуулан магтсан кино юм. (Дэлгэрмаа Б. 2015)

Улс төр, соёлын нөхцөл

Барууны кино нь ёс суртахууны тодорхой хязгаарлалтад (жишээ нь *Naus Code*, МРАА зэрэг) захирагддаг байсан ч улс төрийн хувьд харьцангуй бие даасан шинжтэй байсан юм. Харин социалист кино ямагт коммунист намын хороо, соёлын яамны хяналтаар шууд ордог байлаа. Зөвлөлтийн жишээгээр бол, кино зохиолын эцсийн хувилбар бүрийг “үзэл суртлын зөвшөөрөл”-тэй байх ёстой гэж ханддаг байжээ. (Ковалов О. 2004)

Барууны кино ардчилал, эрх чөлөөг магтан дуулахдаа шууд бус суртал ухуулгын аргыг хэрэглэдэг байсан бол социалист кино ил тод суртал ухуулгын хэрэгсэл болж, “шинэ хүн”, “баатарлаг ажилчин анги”-ийг хүмүүжүүлэн төлөвшүүлэхэд чиглэж байв.

Голливуд дэлхийн киноны зах зээлийг эзэлснээр капиталист үнэт зүйлсийг дэлхий даяар түгээж эхэлсэн бол социалист кинонууд ЗХУ, Монгол, Зүүн Европ, Хятад, Куба зэрэг социалсит улсууд дотор л голчлон түгэж байлаа.

1957 онд Прага хотноо болсон социалист орнуудын кино бүтээлчдийн анхдугаар Бага хурлаас найруулагч С.Гэндэнгийн “Сэрэлт”, Ц.Зандраагийн “Орчин үеийн Монгол улс”, Р.Доржпаламын “Бидэнд юу саад болж байна” кинонууд өндөр үнэлэлт авч Карловы Варын Олон улсын киноны Их наадмын шагнал хүртсэний гадна уул кинонууд Орос, Англи, Хятад хэлнээ орчуулагдан ЗХУ, БНСЧСУ, БНАГУ, БНАСАУ зэрэг орнуудаас захиалга аван, дэлхийн олон орны дэлгэцээр гарч байсан юм. 1959 оноос эхлэн ЗХУ-ын нийслэл Москва хотноо хоёр жил дутам болдог олон улсын киноны Их наадамд найруулагч Д.Жигжидийн “Ардын элч”, “Үер”, “Өглөө”, “Хүргэн хүү”, “Улаанбаатарт байгаа миний аав”, Р.Доржпалам найруулагчийн “Ичээнд нь”, “Моторын дуу”, Х.Дамдингийн “Улаан дарцаг”, Д.Хишигтийн “Тус биш ус”, Ж.Бунтарын “Нар хиртсэн жил” уран

сайхны кинонууд оролцон зохих шагналуудыг хүртэж байсны дотор “Ардын элч” кинонд Ариунаагийн дүрийг бүтээсэн жүжигчин П.Цэвэлсүрэн уул дүрээрээ эмэгтэй жүжигчний мөнгөн медалийн шагналыг олон улсын киноны их наадмаас анхлан хүртсэн байна. Москвагийн олон улсын киноны наадмаас 1969 онд Ц.Навааны “Түмний эх” баримтат кино спортын кино “Болор талст” тусгай шагнал хүртэж байжээ. (Монголын кино урлаг. 1989)

II. ШАШИН БА СҮСЭГ БИШРЭЛИЙГ ИЛЭРХИЙЛСЭН БАЙДАЛ

Шашны асуудал дээр барууны ба социалист кинонуудад маш тод ялгаа гарч байв. Барууны кино шашин, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, оршихуйн мөн чанарын асуудлыг ёс суртахууны нэгэн гол хэмжүүр болгон харуулж байв. Ben-Hur (1959), The Seventh Seal (1957) зэрэг кинонууд итгэл үнэмшил ба эргэлзээ тээнэгэлзэл, амьдралын утга учрыг эрэлхийлсэн байдаг. Харин социалист кинонд шашныг өнгөрсөн үеийн хоцрогдол, бурангуй үзэл гэж авч үзэж, шашинтай холбоотой асуудлыг бүх талаар үгүйсгэдэг байв. Тэд “итгэл үнэмшил” гэдгийг социализм ба хүний оюун ухаанд итгэх итгэл гэсэн талаас үзүүлж байсан юм. Мөн дайснуудыг дүрслэхдээ ч ялгаатай байр суурьтай байв. Барууны кинонд дарангуйллын дэглэм, эрх мэдлийн системийг гол эсрэг дүр болгодог бол социалист кинонд империалист, капиталист, хорлон сүйтгэгчдийг “хөгжил дэвшлийн эсрэг үзэл суртлын дайсан” гэж харуулдаг байв.

Монголын кино урлаг дахь шашны дүрслэл

Монголын кино урлаг дахь шашны сэдэв нь хоёр түүхэн үе шатанд тодорхой илэрдэг. Үүнд: социалист үе (1990 оноос өмнө) болон ардчилсан үе (1990 оноос хойш) юм. Социализмын үед төр нь кино урлагийг үзэл суртлын хүмүүжил, суртал ухуулгын хэрэгсэл болгон хөгжүүлж,

боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, дэд бүтцэд ихээхэн хөрөнгө оруулсан (Батмөнх, 2015). Гэсэн хэдий ч энэ үед буддизмыг нэг талыг барьсан, сөрөг өнцгөөс дүрсэлж байсан нь шүүмжлэл дагуулсаар ирсэн. Энэхүү судалгаа нь социалист үеийн кинонууд буддизмын мөн чанарыг хэр зэрэг гуйвуулан үзүүлсэн эсэхийг шинжилдэг.

Буддизм ба социалист кино

Буддизм Монголд гурван үе шаттайгаар дэлгэрсэн гэж судлаачид үздэг. Эртний үеэс эхлэн XVII-XX зууны хооронд Гэлүг урсгал давамгайлах болжээ. 1921 оны хувьсгалаас хойш төр нь шашин, төрийг салгах бодлого баримталж, атеизмийг албан ёсоор дэмжсэн. 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн үеэр сүм хийд, лам нарын дийлэнх нь устгагдсан. (Монгол Улсын түүх, 2003)

1935 оноос эхэлсэн Монголын кино урлагийг төр антирелигиоз суртал ухуулгын гол хэрэгсэл болгон ашигласан. 1960 оны Үндсэн хууль “атеизмийг сурталчлах”-ыг зөвшөөрч, 1974 оны №34 тогтоолоор шашны үзлийг “шинжлэх ухаанч үзэл”-ээр орлуулахыг уриалжээ. Үүний улмаас лам, хийд, зан үйлийн дүрслэлүүдийг “хуучин, хоцрогдсон үзэл”-ийн илэрхийлэл болгон үзүүлсэн. (Батчулуун С. 2009)

Үүний жишээнд “Цогт тайж” (1945), “Сэрэлт” (1957), “Тунгалаг Тамир” (1970-1973) багтана.

“Цогт тайж” (1945)

Ю.Тарич, Б.Ринчен нарын бүтээл “Цогт тайж” нь Монголын кино урлагийн эхэн үеийн бэлгэ тэмдэг болсон уран бүтээл юм. XVII зууны язгууртан Цогт тайжийн түүхээр дамжуулан үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэл, Төвд лам нарын нөлөөнд эсэргүүцэл үзүүлсэн үйл явдлыг харуулдаг. (Гантуяа М. 2014) Шашныг гадаад нөлөөний хэрэгсэл, харин гол баатрыг ухаалаг, эх оронч үзэлтэй хүнээр дүрсэлжээ. Кино нь түүхэн үнэн ба үзэл суртлын агуулгыг хослуулж, шашны мөргөлдөөнийг улс төрийн бэлгэдэл болгон үзүүлсэн.

“Сэрэлт” (1957)

Энэхүү кино нь уламжлалт шашны үзэл болон шинжлэх ухаанч сэтгэлгээний зөрчлийг харуулдаг. Маарамба (буддын эмч) ба орос эмч хоёрын зөрчил нь шашин ба шинжлэх ухааны тэмцлийг илэрхийлдэг. Төгсгөлд нь энэрэл нигүүлсэхүй, мэдлэг ухаан ялж, хүний амь нас, хүмүүнлэг үзэл санааны үнэ цэнийг магтдаг. Хэдийгээр шашны эсрэг өнгө аяс давамгайл ч, кинонд Буддын анагаах ухааны түүхэн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, нийгмийн шинэчлэл, соёлын шилжилтийг харуулдаг. (Черненко М. 1976)

“Тунгалаг Тамир” (1970-1973)

Ч. Лодойдамбын романаас сэдэвлэсэн энэхүү гурван ангит кино нь 1920-иод оны хувьсгал, нийгмийн өөрчлөлтийг харуулсан том хэмжээний бүтээл юм. Шашны байгууллагыг феодал ёсны тулгуур, лам нарыг шинэ нийгэмд саад учруулагч хүч болгон дүрсэлдэг. Гэсэн хэдий ч кино нь байгаль, ариусал, зовлон, нигүүлсэл зэрэг буддын уламжлалт бэлгэдлийг хадгалж, тэдгээрийг социалист хүмүүнлэгийн үзэлтэй уялдуулан шинэчилж үзүүлжээ. Иймээс уг бүтээл нь үзэл суртал чанартайгаас гадна гүн ухааны утга санааг ч илэрхийлдэг.

Буддизм нь Монголын соёл, ёс суртахуун, урлагт гүн нөлөө үзүүлсэн ч социалист үед кино урлагийг атеист үзэл төлөвшүүлэх хэрэгсэл болгон ашиглажээ. Гурван киноны шинжилгээнээс дараах онцлогууд илэрнэ:

- Үзэл суртлын үүрэг: Буддизм нь “хуучин ертөнцийн бэлгэ тэмдэг” болж дүрслэгддэг;
- Үндэсний тайлбар: Шашны бэлгэдлүүдийг тусгаар тогтнолын үзэл санаатай холбон ашигласан;
- Уран сайхны залгамж чанар: Буддын бэлгэдэл, зан үйл, байгалийн ариун чанарыг дээдлэх үзлийг хадгалсан;
- Хүмүүнлэгийн хувиргалт: Буддын нигүүлсэл, нигүүлсэхүй ёс суртахууныг социалист үнэт зүйлд шилжүүлсэн.

Ш.ДҮГНЭЛТ

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд, 1990 оноос өмнө барууны болон социалист кино урлаг нь үзэл суртлын хувьд эсрэг тэсрэг хоёр тал болж, Монгол кино ч үүний дагуу социалист үнэт зүйл, хамтын ажиллагаа, нийтлэг зорилгыг сурталчилж байсан нь энэ үеийн кинонуудаас тодорхой харагддаг.

Ийнхүү 1990 оноос өмнө барууны болон социалист кино урлаг нь үзэл суртлын хувьд эсрэг тэсрэг хоёр тал болж, хоорондоо өрсөлдөж байсан бөгөөд барууны кинонууд капиталист нийгмийн хүрээнд хувь хүний эрх чөлөө, уран бүтээлийн бие даасан байдлыг алдаршуулж байсан бол социалист кинонууд эв хамтын ухамсар, социалист нийгмийн үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэж байв. 20-р зууны кино урлаг нь зөвхөн уран бүтээл төдий бус, нийгэм, түүх, хүн төрөлхтний мөн чанарын тухай тухай хоёр өөр үзэл санааны тулааны талбар болж байсан юм.

Социалист кино буддизмыг бүрэн няцаах бус, харин түүнийг секуляр утгаар шинэчлэн, шашны бэлгэдлийг нийгмийн шинэ үнэт зүйлсийн илэрхийлэл болгосон. Харин постсоциалист үед эдгээр кино нь шашин ба шинэчлэлийн хоорондын тэнцвэрийг эрж хайсан түүхэн соёлын өв болон үнэлэгдэж байна. (Гантуяа М. 2024)

1980-аад оны сүүлээр Зөвлөлт Холбоот Улс задрах үед барууны ба социалист нийгмийн хоорондох үзэл суртлын ялгаа бүдгэрч эхэлсэн юм. Социалист кино үйлдвэрүүд зах зээлийн эдийн засагт дасан зохицох шаардлагатай болж, кино үйлдвэрлэлийг төрөөс дэмжин, ивээн тэтгэхээ зогсоож, арилжааны кино зонхилох байр суурь эзлэх болов. Барууны кино найруулагчид ч мөн “үзэл суртлын дараах” эрин үед орж, хүйтэн дайны хил хязгаар алдагдан, глобалчлал, олон талт ертөнцийн тухай сэдвийг судлах болсон билээ. Ингэснээр киноны суртал ухуулгын үүрэг улам бүр бүдгэрсээр байна.

Ашигласан материал

- Батчулуун С. (2009) Монгол кино үйлдвэр үүсэж хөгжсөн түүхэн баримт. Улаанбаатар: Мөнх дардас хэвлэлийн компани
- Гантуяа М. (2014), Монголчуудын хутагт тодруулах ёсны судалгаа (япон хэлээр) // Японы Отани ИС-ийн Шин Буддын судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг. 2014 №3. Киото. Х. 237-250.
- Гантуяа М. (2024), Шашны асуудлаарх Монгол төрийн бодлогын гүн ухаан // Философи, эрхийн судлал 2024
- Дэлгэрмаа Б., Дэлгэрбаяр Б. (2015) Кино ба ёс суртахуун (Кино и мораль). УБ: Удам соёл
- Монгол Улсын түүх, (2003), V боть (XX зуун), х. 384, Улаанбаатар
- Монголын кино урлаг. (1989) УБ: УХГ
- Монголын киноны шүүмж: Мотор дуугарлаа. (2015). УБ: Бемби сан
- Geoffrey Newell-Smith, (1996), The Oxford History of World Cinema. Oxford University Press
- Peter Kenez. (1992) Cinema and Soviet Society, 1917-19536 Cambridge University Press.
- Tony Shaw, (2010). Cinematic Cold War: The American and Soviet Struggle for Hearts and Minds. University Press of Kansas
- Ковалов О., Кудрявцев С. (2004). Практика цензуры зарубежных фильмов подвергается резкой критике на секретариате СК СССР // Новейшая история отечественного кино. 1986-2000. Кино и контекст. СПб.: Сеанс, 2004. Т. 4. [ISBN 978-5-901586-07-5](#)
- Платонова, Э.Е. (2003). Тенденции в литературе и кинематографе в конце XX века // Культурология: учеб. пособие. М.: Академический Проект
- Черненко М. (1976). Кино Монголии. Москва